

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019.08.01

Нийслэлийн Байгаль орчны газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2019 онд Минж нутагшуулах төвийн барилгын засварын ажил гүйцэтгүүлэх [НБОГ-2019/010] дугаартай ажлыг** гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа хялбаршуулсан цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийг **2019 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 10⁰⁰**-аас өмнө төрийн худалдан авах ажиллагааны (www.tender.gov.mn) системд илгээх ба тендерийг **2019 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 10³⁰** –д нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **тооцно.**

Гадаадын этгээд оролцох **эрхгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Жигжиджавын гудамж-9, Харгарди ордон 406 тоот,**

Утас 11323780, 11318003

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**6. Алдааг
залруулах**

- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

**7. Санал
болгосон
үнэ, түүнийг
үнэлэх**

- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах
эрх олгох
тухай
мэдэгдэл**

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлсээс бүрдэнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны аль нэг жилд 30 000 000 /гучин сая/ төгрөгийн үнийн дүнтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн ажлын жагсаалт, гэрээн, ажил хүлээлцсэн акт, захиалагчийн тодорхойлолтыг хуулбарлан ирүүлэх <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: шаардлагатай</p> <p>шинээр бол:</p> <ol style="list-style-type: none"> 1. БА-8.1: Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил 2. БА-6.3: Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна шугам сүлжээний угсралт болон түүнээс дээш <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шат, түрдэг тэрэг, тасдагч, гагнуурын аппарат, цахилгаан хөрөө, дрилл, бага оврын цахилгаан үүсгүүр /фото зураг хавсаргаж ирүүлнэ/ 2. Бага оврын ачааны машин /гэрээт байж болно/ 3. Хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэл хүний тоогоор байх.
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Чингэлтэй дүүрэг, Ц.Жигжиджавын гудамж-7/1, Нийслэлийн Засаг захиргааны 2 дугаар байр, Давхар болон ерөөний дугаар: 4 давхар Нийслэлийн Байгаль орчны газар- 406 тоот Утас: 11323780, 11318003, Огноо: 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдөр Цаг: 10⁰⁰</p>

<p>ТӨӨЗ 2.1.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Чингэлтэй дүүрэг, Ц.Жигжиджавын гудамж-7/1, Нийслэлийн Засаг Захиргааны 2 дугаар байр, Давхар болон өрөөний дугаар: 4 давхар Нийслэлийн Байгаль орчны газар: 406 тоот Утас: 11323780, 11318003 Огноо: 2019 оны 08 дугаар сарын 8-ны өдөр Цаг: 10 цаг 30 минут</p>
<p>ТӨӨЗ 3.1 (а)</p>	<p>Шаардлага хангасан үнийн санал</p>
<p>ТӨӨЗ 3.1 (б)</p>	<p>Ажил гүйцэтгэх хугацааны график /Хуанлийн 30 хоногт багтаан гүйцэтгэх/</p>
<p>ТӨӨЗ 3.1 (г)</p>	<p>Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: туйм</p>
<p>ТӨӨЗ 3.1 (д)</p>	<ul style="list-style-type: none"> - Байгууллагийн товч танилцуулга - Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийг урилга, татварын тодорхойлолт батлуулсан хуулбарыг ирүүлэх - Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг эх хувиар ирүүлнэ. - Тендерт оролцогчийн харъяа аймаг, дүүргийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын шүүхийн тодорхойлолт <p>Төсвийг зураг, ажлын тоо хэмжээний дагуу тооцож эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулж ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> - ЗТБХБ-ын сайдын 2012 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 18 тоот, 2012 оны 181 дүгээр тушаалуудаар батлагдсан төсөв зохиох дүрмийн дагуу тооцно. - БХБСайдын 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 185 дугаар тушаалын дагуу зохиогчийн хяналтын зардлыг тооцож ирүүлнэ. - Магадлашгүй ажлын зардал, норм нормативийн сангийн зардлыг төсөв зохиох зааврын дагуу, татвар хураамжийг холбогдох хуульд нийцүүлэн тус тус тооцож ирүүлнэ. - Захиалагч байгууллагаас зураг төсвийн үнийг тендерийн үнийн саналд тусгуулахаар заасан тохиолдолд төсөвт тооцож ирүүлнэ. - Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох программаар гүйцэтгэнэ. - Үнийн хөнгөлөлт тооцсон тохиолдолд задаргаа болон үндэслэлийн хамт ирүүлнэ. - Төсөвт арифметик алдаа болон орхигдуулсан жижиг хэмжээний зөрүүг залруулах, үнийн хөнгөлөлтийг харгалзан тендерийн үнийг бууруулах, давуу эрх эдлэх этгээдийн хувь хэмжээг тооцож, үнэлгээний бусад шалгуур үзүүлэлтийг сонгосон бол тэдгээрт харгалзах саналуудыг мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэ дээр харгалзан тооцож тендерийн харьцуулах үнийг тодорхойлно. Их хэмжээний зөрүүтэй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно. <p>Шалгарсан тохиолдолд гэрээний үнийн дүн, ажил гүйцэтгэх үе шатны хуваарьт багтаан ажлыг чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөх тухай баталгааг албан бичгээр</p>

ирүүлнэ.

- Уг ажлыг гүйцэтгэхэд ашиглагдаж буй материал түүхий эд болон тухайн ажлыг гүйцэтгэх менежмент нь Байгаль орчин, амьтанд ээлтэй технологиор гүйцэтгэсэн бол энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлнэ.
- Инженер техникийн ажилтнуудын сургууль төгссөн диплом, цахим үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар ирүүлнэ. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтны гэрчилгээг ирүүлнэ.
/Барилгын инженер, цахилгааны инженерийн аль нэг нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байна/

Дараах хүснэгтэд үзүүлсэн удирдах болон инженер техникийн ажилтныг ажиллуулна

Албан тушаал	Хүний тоо	Ажлын туршлага
Барилгын инженер	1	2-аас дээш жил ажилласан байх Үндсэн ажилтан байна
Цахилгааны инженер	1	1-ээс дээш жил ажилласан байх Гэрээт ажилтан байна
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан инженер	1	1-ээс дээш жил ажилласан байх Үндсэн ажилтан байна

- ИТА-ын хувьд 1-ээс доошгүй нь үндсэн ажилтан байх ба нийгмийн даатгалын шимтгэлийг 3 сараас багагүй хугацаанд төлсөн байна. Нийгмийн даатгалын НД8 маягтаар баталгаажуулсан тайлан ирүүлнэ. Гэрээт ажилтны хувьд хөдөлмөрийн гэрээг хавсарган ирүүлнэ.
- Тендерийн баримт бичгийн ТШӨХ-нд заасан шаардлагыг хангаагүй, материалуудыг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Үнийн санал, ажил гүйцэтгэх хуваарь, гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарийг батлаж ирүүлнэ.
2. Ажлын талбай, түүний байршил, нөхцөл байдалтай газар дээр нь танилцсан байх
3. Тухайн ажлыг гүйцэтгэхдээ норм ба дүрэм стандартыг барьж ажиллах
4. Мөн бүх материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн эрүүл ахуйн шаардлагийг хангасан байна.
6. Ажлыг гэрээт хугацаандаа чанарын шаардлагыг хангаж, бүрэн гүйцэтгэх.
7. Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрэн хангаж, үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна.
8. Ажлын тоо хэмжээг сонгон шалгаруулалтанд оролцогчийн удирдамж, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт болон зурагтай холбож ойлгоно.
9. Захиалагчийн зураг төслийн ажлын зардал 250 000 /хоёр зуун таван мянга/ төгрөгийг төсөвт тусгаж өгнө.
10. Барилгын ажлын засварыг мэргэшсэн төсөвчнөөр батлуулж ирүүлэх.

ТУСГАЙ ШААРДЛАГА

- Ажлын батлагдсан зураг төсөл болон холбогдох стандарт, норм, дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэнэ.
- Минж нутагшуулах төвийн байрнуудыг байгалийн гаралтай түүхий эдээр хийгдсэн байгаль орчинд болон хүний бие, минжний эрүүл мэндэд ямар нэгэн нөлөөгүй усан суурьтай будаг ашиглах
- Хуучин будагтай ханыг ус чийгэнд тэсвэртэй, хөгц мөөгөнцөр үүсэхгүй сайн чанарын будгаар будах
- Минж үржүүлгийн төвийн байранд засвар хийхдээ дуу чимээ багатай сүүлийн үеийн тоног төхөөрөмж хэрэглэх
- Минж үржүүлгийн байрны иргэд олон нийтийн минжний урдуур явж үзэх хамгаалалтын хашлагыг биетэй төмрөөр бат бэх суурьлуулах
- Минж нутагшуулах төвийн барилгын дээврүүдийг бат бэх салхи шуурганд дуугарахааргүй, борооны ус нэвтрэхгүй төмрөн бусад материалаар хийж гүйцэтгэх
- Ажлын явцад гарсан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаях ба ажил дууссаны дараа талбайг цэвэрлэж хүлээлгэн өгнө.
- Хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг хуульд заасны дагуу мөрдөж, түүнд шаардагдах хөрөнгийг хуулийн дагуу төлөвлөж, ажлын төсөвт багтааж, зарцуулах
- Иргэдийн аюулгүй байдлыг бүрэн хангаж, ажлын байр, зам талбайг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу бэлтгэж, ажлыг аюулгүй гүйцэтгэх нөхцлийг бүрэн хангах, хашаа хамгаалалтыг хийж анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг хийх. Ажилтнууд хамгаалах хэрэгслэлээр бүрэн хангагдсан байна.

- Гүйцэтгэгч нь захиалагч байгууллагуудтай уялдаатай ажиллана.
- Ажлыг гүйцэтгэх үед минжний тохижилт, зогсоол, явган зам, камер, цахилгаан, интернетийн кабель утсыг гэмтээсэн тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр түргэн шуурхай засварлан захиалагч байгууллагад хүлээлгэн өгнө.
- Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрэн хангах, үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна.
- Байгалийн гэнэтийн гамшиг, гал түймэр, үер усны гамшигаас сэргийлэн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллана.

Минж нутагшуулах төвийн барилгын засварын ажлын даалгавар

НБОГазар

Минж нутагшуулах төвийн барилга

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

МИНЖНИЙ БАЙРНЫ ЗАСВАР

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Тамбурын довжоог орготгож цутгах м100	м3	1
2	Тамбурын 250 мм-ийн тоосгон хана цемент зуурмагаар гагнаж өрөх	м3	3.3
3	2.5м хүртэл урт модон ялуу хийж угсрах	ш	2
4	Тамбурын саравчинд уур тусгаарлагч наах	м2	6
5	Тамбурын саравчи дээр модон сараалжтай долгионт төмөр дээвэр хийх	м2	7.5
6	Гадна хаалга буулгах /2ш/	м2	3.8
7	Бүргэд хаалга суулгах	ш	2
8	Тамбурын модон самбартай хаалга суулгах	ш	1
9	Хуучин будагтай ханыг ус чийгэнд тэсвэртэй тикурила брендийн будгаар сайн чанартай будах	м2	542.17
10	Дээврийн татанг тосон будгаар будах	тн	1.1
11	Хамгаалалтын төмөр сараалжин хашлага хийж угсрах	м2	23
12	Хамгаалалтын томор сараалжин хашлага будах	тн	0.177
13	Ус буулгагч вентель Ф40 солих	ш	15
14	Цонхонд хуйлагддаг хулдаасан хошиг тогтоох	ш	15
15	Автомат / 80а-хүртэл/ солих	ш	2

ДИЗЕЛЬ ЦАХИЛГААН ҮҮСГҮҮР, ГҮНИЙ ХУДАГИЙН БАРИЛГЫН ЗАСВАР

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Даацын нухтэй болокоор хана битүүлж өрөх	м2	1.14
2	Төмөр рамтай гадагш онгойдог дулаалгагүй хаалга угсрах	м2	2.55
3	Гадна ханыг цементэн зуурмагаар шавардах	м2	39
4	Гадна хана эмульсэн будгаар будах	м2	39
5	Хөөсөнцөр дулаалгатай төмөр сендвич хавтангаар дээвэр хийх	м2	21
6	0.60x0.8 хэмжээтэй пластмасан цонх гараар угсрах /худагийн барилгын/	1 блок	1

СУРГАЛТЫН БАЙРНЫ ЗАСВАР

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Дуужин тааз задлаж буулгах /80%-ийг эргүүлж ашиглана/	м2	81
2	Тамбурын тааз задлаж буулгах	м2	13.5
3	Ханын гипсэн бүрээс буулгах /80%-ийг эргүүлж ашиглана/	м2	80.1
4	Барилгын хог ялгаж овоолох ба автомашинд ачих	м3	3
5	Дуужин тааз угсрах /20% шинээр хийхээр тооцсон/	м2	81
6	Гипсэн хана угсрах /20%-ийг шинээр хийхээр тооцсон/	м2	80.1
7	Тамбурын таазыг харуулдсан банзаар бүрэх	м2	13.5
8	Хананд тэгшилгээ хийх /замаска/	м2	80.1
9	Хананд эмульсэн будаг хийх	м2	80.1
10	Тамбурын модон тааз өнгийн тосон будагаар, гар аргаар сайн чанартай будах	м2	13.5

ОФФИСЫН БАЙРНЫ ЗАСВАР

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Дуужин тааз задлаж буулгах /80%-ийг эргүүлж ашиглана/	м2	23
2	Ханын гипсэн бүрээс буулгах /80%-ийг эргүүлж ашиглана/	м2	44.6

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

3	Барилгын хог ялгаж овоолох ба автомашинд ачих	м3	0.8
4	Дүүжин тааз угсрах /20%-ийг шинээр хийнэ/	м2	23
5	Гипсэн хана угсрах /20%-ийг шинээр хийнэ/	м2	44.6
6	Хананд тэгшилгээ хийх /замаска/	м2	44.6
7	Хананд эмульсэн будаг хийх	м2	44.6

АЖИЛЧДЫН БАЙРНЫ ЗАСВАР

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Дуужин тааз задлаж буулгах/80%-ийг эргүүлж ашиглах/	м2	49
2	Ханын гипсэн бүрээс буулгах /80%-ийг эргүүлж ашиглана/	м2	88.87
3	Барилгын хог ялгаж овоолох ба автомашинд ачих	м3	1.7
4	Дүүжин тааз угсрах /20%-ийг шинээр хийхээр тооцсон/	м2	49
5	Гипсэн хана угсрах /20%-ийг шинээр хийхээр тооцсон/	м2	88.87
6	Хананд тэгшилгээ хийх /замаска/	м2	88.87
7	Хананд эмульсэн будаг хийх	м2	88.87

БИЕ ЗАСАХ ГАЗРЫН ЗАСВАР

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Гадна хана хөөсөнцөрөөр дулаалах	м2	37
2	Гадна хананд тортой шавар хийх	м2	37
3	Гадна хана эмульсэн будгаар механик аргаар будах	м2	37
4	Таазанд шүршдэг хөөсөн дулаалга хийх	м2	21
5	Ердийн нөхцөлд ажиллах гипсэн тааз угсрах	м2	21
6	Тааз усан шийдэм будгаар өнхрүүлгээр өндөр чанартай будах	м2	21

Тав. ЗУРАГ

Зургийн санамж

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны

гарын үсэг, тамга: Албан

тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх**
 - 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
 2. **Төслийн менежерийн шийдвэр**
 - 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
 3. **Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх**
 - 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
 4. **Аюулгүй байдал**
 - 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
 - 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
 5. **Зааварчилгаа**
 - 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
 6. **Маргааныг шийдвэрлэх**
 - 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
- Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**
7. **Ажлын хөтөлбөр**
 - 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэд дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
 - 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
 8. **Зөрчил, гологдол илрүүлэх**
 - 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

**9. Зөрчил,
гологдол
арилгах**

9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.

- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн

дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

**17.
Ашиглал
т,
засвар,
үйлчилгээн
и**

17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт,

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

18. Гэрээг цуцлах

18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

20.
Гүйцэтгэлэ
эс
чөлөөлөх

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2019 онд минж нутагшуулах төвийн барилгын засварын ажил гүйцэтгүүлэх /НБОГ-2019/010/
ГЕН 2.1	Ажил нь: Ажлын тоо хэмжээ болон техникийн тодорхойлолт -оос бүрдэнэ. Ажлын талбай нь Баянзүрх дүүрэг, 20-р хороо, Гачуурт тосгон, Минж нутагшуулах төв -д байршина
ГЕН 3.1	Төслийн менежер нь: БОЯБХМНХ-ийн амьтан ургамал хариуцсан мэргэжилтэн Ц.Цолмонбаатар
ГЕН 4.1	Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 30 хоног
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа: Барилгын тухай хуулийн 14.6 заалтын дагуу 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш 1 жил байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,01% байна. ⁵
	Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10 хувь байна.
ГЕН 16.1	Санхүүжилтийг ажил гүйцэтгэсэн хуваарийн дагуу санхүүжүүлнэ. 2 байрны засварыг бүрэн дуусахад санхүүжилтын 50 хувь олгоно. Ажлыг бүрэн хийж дуусан эцсийн тайлан хүлээлгэн өгөхөд 50 хувь олгоно.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [огноо] -ны дотор гаргаж өгнө.
	Гүйцэтгэлийн зургийг [огноо] -ны дотор гаргаж өгнө.
	Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [мөнгөн дүн] байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 0 хувь -иар тооцно.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний

тусгай нөхцөлд хавсаргана.

4 Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

5 Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Гарын үсэг) (Албан

_____ (Гарын үсэг)

_____ тушаал)

_____ (Албан

_____ тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны сарын_ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/
Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____

_____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____
Хүчин
чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-
_____ суурь, _____ хана, _____
_____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын
засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг инженерийн шугам сүлжээ

/дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/,_____туслах барилга /бусад ажил/-ын хамт
_____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр эхэлж,_____оны дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;

- 5.8. Гүйцэтгэчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]